



УЛААНБААТАР  
ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН ХУРЛЫН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ

ТОГТООЛ

1987 оны 7  
сарын 16 өдөр

Дугаар 202

Улаанбаатар  
хот

Хөнгөвчилсэн сургалттай  
тусгай бүлэг байгуулах  
тухай

Налайхын районы хөдөлмөрчдөөс Ардын боловсролын яам, Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанд ирүүлсэн хүсэлтийн дагуу тус районы ерөнхий боловсролын 6 сургуулийн 62 сурагчийг хамран явуулсан эмнэлэг сурган хүмүүжүүлэх комиссын үзлэгийн шалгалт, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1986 оны 219 дүгээр тогтоолын заалтыг үндэслэн Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

1. Тус районд 1987-1988 оны хичээлийн жилээс эхлэн нэг, хоёрдугаар ангийн тус бүр нэг бүлгийг 16-20 сурагчтайгаар 10 жилийн хоёрдугаар сургуулийн дэргэд байгуулан ажиллуулсугай.

2. Тусгай бүлгийн хичээллэх байр гаргаж, анги зохион байгуулалт хийхийн хамт энэхүү тусгай бүлэгт шаардагдах төсвийг зохих зааврын дагуу 10 жилийн хоёрдугаар сургуулийн төсөвт нэмж тусгуулахыг Налайхын районы АДХ-ын гүйцэтгэх захиргаа /н.Манцан/-д даалгасугай.

3. Тусгай бүлгийн сургалт хүмүүжлийн ажилт ба нгын удирдлага мэргэжлийн багшаар хангаж, арга зүйн тусламцаа үзүүлэн ажиллахыг Ардын боловсролын удирдах газар /н.Затмэгнаа/-д даалгасугай.

4. Үзлэгт хамрагдаагүй хүүхдийг нөхөн энэ оны ҮШ сард багтааж үзлэгт оруулахын хамт мэргэжлийн холбогдох байгууллагуудтай хамтран тус район болон нийслэл хотод оруулж комсомолтой хүүхэд олон байгаагийн шалтгааныг тал бүрээс нь судалж, савал дүгнэлт гарган

хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны тэргүүлэгчдийн хуралд энэ онд багтаан танилцуулахыг Эрүүлийг хамгаалах газар /н.Бямбаа/-д даалгасугай.



УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРГААНЫ ДАРГА *[Signature]* С.МОНХМАРТАЛ

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРГААНЫ ХАРИУЦАГАГАЙ НАРИЙН  
БИЧИЙН ДАРГА *[Signature]* Д.АЛША